

**“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 27

№ 01

Дархан-Уул аймаг

**Санхүүгийн болон үйл ажиллагааны
тайлан батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалт, “Дархан зочид буудал” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ :**

1. **“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн санхүүгийн тайланг хангалттай хэмээн үзсүгэй.**
2. **“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн 2017 онд / 32.749.135.99 /төгрөгийн алдагдалтай ажилласантай холбогдуулан ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосон ТУЗ-ийн шийдвэрийг баталсугай.**
3. **2018 онд бизнесийн болон үйл ажиллагааг эрчимжүүлж, цаашид ашигтай ажиллах талаар идэвх санаачлага гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал / Б.Ганпүрэв /-т даалгасугай.**

ХУРЛЫН ДАРГА-*bol*



Н.МӨНХДАШ

**“ ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 27

№ 02

Дархан Уул аймаг

**ТУЗ-ийн гишүүдийн бүрэн
Эрхийг дуусгавар болгох тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт “ Дархан зочид буудал” ХК –ийн 2018 оны 04 сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүн, хурлын тэмдэглэлийг үндэслэн

ТОГТООХ НЬ:

Нэг. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дараах нэр бүхий гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.

Үүнд:

Н.Мөнхдаш, П.Алимаа, Л.Ариунзаяа, Б.Мягмардаш, Н.Пүрэвдаш, Л.Ариунтуяа, Б.Энхбаяр, Э.Мянганбаяр, О.Хүрэлчулуун.

ХУРЛЫН ДАРГА-ыг



Н.МӨНХДАШ

**“ ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 27

№ 03

Дархан-Уул аймаг

ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт “ Дархан зочид буудал” ХК –ийн 2018 оны 04 сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүн, хурлын тэмдэглэлийг үндэслэн

ТОГТООХ НЬ :

Нэг. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Н.Мөнхдаш
2. Б.Ганпүрэв
3. П.Алимаа
4. Б.Мягмардаш
5. Н.Пүрэвдаш
6. Д.Даянбилгүүн

Хоёр. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Б.Энхбаяр
2. Л.Ариунтуяа
3. Э.Мянганбаяр

Гурав. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА-ыг



Н. МӨНХДАШ